

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

Г “Даатгагчийн хөрөнгийг тусгаарлан г
байршуулах, түүний зарцуулалтад хяналт тавих
журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Даатгагчийн хөрөнгийг тусгаарлан байршуулах, түүний зарцуулалтад хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журмыг 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАГЧИЙН ХӨРӨНГИЙГ ТУСГААРЛАН БАЙРШУУЛАХ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-нь Даатгалын тухай хуулийн 68.1.1, 68.1.2, 68.1.3-д заасан албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр болсон давхар даатгалын, ердийн болон болон урт хугацааны даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-ийн дүрмийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг банкин дахь тусгай зориулалтын аккредитив дансанд байршуулах, түүний зарцуулалтад хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмын дор дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:

1.2.1. “Зориулалтын данс” гэж энэхүү журмын 2.1 дэх заалтын дагуу Хорооноос хяналт тавьж буй даатгагчийн банкин дахь аккредитив дансыг;

1.2.2. “Баталгаат хөрөнгө” гэж даатгагчийн мөнгө болон Монгол Улсын Засгийн газар, Монгол банкнаас гаргасан өрийн бичиг ба түүнтэй адилтгах хөрөнгө;

1.2.3. “Доод хэмжээ” гэж даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээний 25 хувьтай тэнцэх хэмжээний баталгаат хөрөнгө, эсхүл Хорооноос тогтоосон энэ журмын 2.2-т заасан баталгаат хөрөнгийн хэмжээг;

1.2.4. “Хэрэг гүйцэтгэгч” гэж Дампуурлын тухай хуулийн 3.1.4-т заасны дагуу шүүхээс томилогдсон этгээдийг;

1.2.5. ”Бүрэн эрхт төлөөлөгч” гэж Даатгалын тухай хуулийн 72.4.2-т заасан этгээдийг хэлнэ.

ХОЁР. Даатгагчийн хөрөнгийг тусгаарлан байршуулах

2.1. Даатгагчийг даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу даатгуулагчдад олговол зохих даатгалын нөхөн төлбөрийг бүрэн олгуулах зорилгоор Хороо нь Даатгалын тухай хуулийн 68.1.1, 68.1.2, 68.1.3-д заасан албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн өмнө даатгагчийг баталгаат хөрөнгөө зориулалтын дансанд аккредитив хэлбэрээр тусгаарлан байршуулах тухай даалгавар өгнө.

2.2. Хороо даатгагчийн тусгаарлан байршуулбал зохих баталгаат хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоож болох бөгөөд ийнхүү тогтоосон баталгаат хөрөнгийн хэмжээ нь Даатгалын тухайн хуулийн 22.1-д заасан даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

2.3. Даатгагчийн зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийн хэмжээ энэ журамд заасан доод хэмжээнд хүрэхгүй тохиолдолд даатгагч банкинд баталгаат хөрөнгө нэмж байршуулах үүрэгтэй.

ГУРАВ. Тусгаарлан байршуулсан хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

3.1. Даатгагч тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийг энэ журамд зааснаас бусад нөхцөл, зорилгоор зарцуулахыг хориглоно.

3.2. Даатгагчийн баталгаат хөрөнгө байршуулсан зориулалтын дансанд банк хүү төлөх нөхцөлтэй бол Хороо нь жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор банкны хүүгийн орлогыг тухайн даатгагчид олгох зөвшөөрлийг бичгээр өгнө.

3.3. Даатгагчаас зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийн хэмжээ нь энэ журмын 2.2-т заасан хэмжээнд хүрэхгүй тохиолдолд Хорооноос дараах үүргийг албан бичгээр даатгагчид хүргүүлнэ:

3.3.1. Баталгаат хөрөнгийн дутууг гүйцээж бүрдүүлэх зорилгоор даатгагчийн баталгаат хөрөнгөд тусгаарлан байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогыг зориулалтын дансанд үлдээх;

3.3.2. Даатгагчаас баталгаат хөрөнгийг нэмж байршуулах.

3.4. Хороо зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд шилжүүлэх зөвшөөрөл олгоно:

3.4.1. Шүүхээс хэрэг гүйцэтгэгч, эсхүл бүрэн эрхт төлөөлөгч томилогдсон тохиолдолд хэрэг гүйцэтгэгч, эсхүл бүрэн эрхт төлөөлөгчид;

3.4.2. Энэ журмын 3.6-д заасан буцаах шийдвэр гарсан тохиолдолд даатгагчид.

3.5. Даатгагчийн зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийг хэрэг гүйцэтгэгч, эсхүл бүрэн эрхт төлөөлөгч нь зөвхөн дараах зориулалтаар зарцуулж болно:

3.5.1. Даатгалын гэрээгээр даатгагчийн хүлээсэн үүргийн дагуу даатгуулагчдад олговол зохих нөхөн төлбөрийг олгох;

3.5.2. Даатгалын гэрээнд заасан үүргийн дагуу даатгуулагчдад олгох нөхөн төлбөрийг бүрэн барагдуулж дууссаны дараа үлдсэн хөрөнгийг Хороонд мэдэгдсэний үндсэн дээр даатгагчийн хувь нийлүүлэгчдэд буцааж олгох.

3.6. Зориулалтын дансанд даатгагчаас тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийг Хороо дараах тохиолдолд даатгагчид буцаах шийдвэр гаргана:

3.6.1. Энэ журмын 2.1-д заасан албадлагын арга хэмжээг авч хэрэгжүүлсний дараа даатгагчийн үйл ажиллагаа эргээд хэвийн болж, Хороо авсан албадлагын арга хэмжээг цуцалсан тохиолдолд баталгаат хөрөнгийг;

3.6.2. Хороо даатгагчийн зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийн хэмжээ нь байвал зохих доод хэмжээнээс их дохиолдолд тухайн давсан хэсгийг.

3.7. Хороо энэ журмын 3.4-т заасны дагуу шилжүүлэх хүртэл даатгагчийн зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийн хадгалалт, найдвартай байдалд хяналт тавина.

3.8. Энэ журмын 3.6-д заасныг үндэслэн даатгагч нь зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгөө буцаан авах тухай хүсэлтээ Хороонд бичгээр ирүүлнэ.

3.9. Хороо энэ журамд заасны дагуу даатгагчаас ирүүлсэн хүсэлтийг хянаж, даатгагч даатгалын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу даатгуулагчдад олговол зохих нөхөн төлбөрийн бүрэн олгож дууссан тохиолдолд зориулалтын дансанд тусгаарлан байршуулсан баталгаат хөрөнгийг даатгагчид буцааж олгоно.

ДӨРӨВ. Хариуцлага

4.1. Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--